



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн малчин болон мал бүхий иргэдийн 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлж өвс татах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

2.Өвс татан авах ажлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж 6,490,000 (Зургаан сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас 4,790,000 (Дөрвөн сая долоон зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг дарга Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны сарын ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Шаардагдах хэмжээ	Бүгд үнэ
1.	Өвс	Боодол	11,000	1000	11,000,000
2.	Ажлын хөлс	Хүн/өдөр	14x20,000	280,000	280,000
Нийт					11,280,000